

БАТЛАВ
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГКЛИЙН ЯМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ХАТГАЛ-ХАНХ ЧИГЛЭЛИЙН 180КМ ХАТУУ ХУЧИЛТАЙ АВТО ЗАМЫН
ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 04 сарын 10-ны өдөр

№ А337-05/34

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах
үндэслэл

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралтын VI.2.4.1, Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаал

2. Байршил

Хөвсгөл аймгийн Хатгал, Чандмань-Өндөр, Рэнчинлхүмбэ, Ханх сумдын нутаг дэвсгэрт

3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр

Улсын төсөв

4. Замын техникийн ангилал, замын зэрэг

Хуримтлуулагч зам (Хөдөлгөөний 2 зуравстай, зорчих хэсэг нь зааглагдаагүй, тооцоот хурд нь 70 км/цаг) -ээс доошгүй ТЭЗҮ-ээр нарийвчлан тогтоох

5. Замын эхлэлийн цэг

А1101 дугаартай Ханх боомт-Хатгал-Мөрөн чиглэлийн авто зам Хатгал сум орчим ТЭЗҮ-ээр тогтоосон цэг (Захиалагчтай зөвшилцэнэ)

6. Замын төгсгөлийн цэг

А1101 дугаартай Ханх боомт-Хатгал-Мөрөн чиглэлийн авто зам Ханх сум ТЭЗҮ-ээр тогтоосон цэг (Захиалагчтай зөвшилцэнэ)

7. Замын хучилтын хийц

Зургийн ерөнхий инженерийн техникийн шийдэл, тооцоогоор сонгох

8. Төлөвлөлтийн норм

- “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016
- “Хот суурины гудамж зам төлөвлөлт” БНБД 32-01-04
- “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01*/2006
- “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88
- “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” МНС4597:2014
- “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн

- дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслийдийг хэрэглэх дүрэм” MNS4596:2014
- “Тахир дуттуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөгийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009
- Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих өрөнхий шаардлага MNS 4598: 2020
- Тал хээр, говь цэлийн бусийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц MNS6515:2015
- Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц Ерөнхий шаардлага MNS6735:2018
- Бусад шаардлагатай Монгол улсын холбогдох 33БНБД, БНБД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.

10. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа

Хоёр үе шаттай, 2024 оны 4 дүгээр улиралд багтаан гүйцэтгэнэ.

11. Зураг төслийн иж бүрдэл

- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэсплэл” БНБД 11-07-04-ийн II хэсэгт инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан;
- Буурь хөрс болон зам барилгын ажилд хэрэглэх түгээмэл тархацтай (чулзуу, далан, суурийн хайрга, хөрс гэх мэт) материалын тойм судалгаа болон буурь хөрс, замын далангийн материалын судалгааг хамруулсан инженер-геологи, геотехникийн хайгуул судалгааны ажлын тайлан;
- Одоо байгаа модон гүүр болон хиймэл байгууламжийн хийц, ашиглалтын байдлын судалгаа дүгнэлт;
- Дараах хэсгүүдийг нэгтгэсэн Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:
 - Тухайн авто замыг барьж бүрэн дуусгахад шаардлагатай (Нийтийн тээвэрт зориулсан түр зам, газрын өнгөн хөрс хуулах, ус өнгөрүүлэх хоолой ба ус зайлцуулах бусад байгууламж, гүүр, ул хөрс солиц, цэвдгийг гэсэлтээс хамгаалахад зориулсан дулаан тусгаарлах ба чuluун асгаасан үе, шороон далан, ухмал, далангийн дээд үе, тусгай үеүд, суурийн дэвсгэр үе, замын суурь ба хучлага, ан амьтныг

хөндлөн гаргах байгууламж, замын тоноглол, бетон барьер, хөдөлгөөн зохицуулалтын ба аюулгүй байдлын хэрэгслийд, тэмдэг ба тэмдэглэл, зогсоол ба амрах талбай, зам, гуурин барилгын зурваст орсон шилэн кабелийг хамгаалах, цас хунгарлалтыг багасгах хэрэгсэл зэрэг) бүх төрлийн ажлын (гэхдээ эдгээрээр зөвхөн хязгаарлагдахгүй) нарийвчилсан зураг,

- Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх ажлын техникийн шаардлага (ТШ),
- Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх төрлийн ажлын болон Барилгын нийт ажлын тоо хэмжээний жагсаалт (АТХЖ),
- Авто замын өргтийн Инженерийн нарийвчилсан тооцоо (ИНТ),
- Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ),
- Байр зүйн судалгааны болон геодезийн хэмжилтийн ажлын дэлгэрэнгүй тайлан,
- Геоморфологи, гидрогеологи, геотехникийн болон материалын олдоцын судалгааны дэлгэрэнгүй тайлан
- Гадаргуугийн усны ба цаг уурын судалгааны дэлгэрэнгүй тайлангаас бурдэнэ.
- Авто зам, гуурин зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан, холбоо, дулаан, шилэн кабелийн шугам сүлжээний зураг тесэл, техникийн нэхцэлийг холбогдох байгууллагуудаас авах, авто замын трасст орсон иргэн аж ахуй нэгжийн газар чөлөөлөх (газар, обьект), нүүлгэн шилжүүлэх ажлын судалгаа гаргах, ажлын тоо хэмжээ, зардал;
- Авто замын барилгын ажилтай холбоотой газар олгосон болон широон орд ашиглах орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нэхцэлүүд;
- Том оврын тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг тесэл;
- Байгаль орчны өрөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээ хийх.
- Авто замын хөндлөн огтлинын зураг төслийг 20 м тутамд хийх.
- Зураг төслийн иж бурдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын өрөнхий дүгнэлт;

- Зураг төслийг Монгол, Англи хэл дээр боловсруулна.
- Зураг төслийг эх хувь 1ш, хуулбар 1ш / хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/, тоон хэлбэрээр /*dwg, *kmtz, *pdf/ хүлээлгэж өгнө. Тоон байдлаар бүх бичиглэлийн материалыг *.doc, *.xls өргөтгөлтэйгөөр, зураглалын материалыг *.dwg, *.shp өргөтгөлтэйгөөр баримт бичгийн бүрдлийг *.pdf өргөтгөлтэйгөөр CD болон DVD-ээр хүлээлгэн өгнө.

12. Зураг төслийн байгууллага

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу шалгарсан хуулийн этгээд

13. Захиалагч байгууллага

Зам, тээврийн хөгжлийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам

14. Онцгой нөхцөл

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар"-аас геодезийн өндөржилтийн цэгийг авах бөгөөд замын трассын дагуу хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхжэх, геодезийн ажлын тайланг тус газарт хүргүүлж, бүртгүүлсэн тухай албан бичгийг ИДТ-д хавсаргах;
- Төлөвлөж буй авто замын трассыг хувилбаруудын харьцуулалтаар сонгон тогтоож, тухайн орон нутгийн удирдлага, Захиалагчид зөвшилцэж санал авах, салбарын Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;
- Зайлшгүй шаардлагатай тохиопдолд олон улсад түгээмэл хэрэглэдэг зохих стандарт, нормыг захиалагчтай зөвшилцэж ашиглаж болно.
- Уулзвар гарц, одоо байгаа замын огцом напуу болон эргэлт бүхий хэсгүүд зэрэг хэсгүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, цогц арга хэмжээг төлөвлөх;
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд төсөллөх, Тээврийн цагдаагийн албанаас санал авах;
- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх инженерийн шийдлийг төсөллөх;
- Халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх;
- Мал амьтны зам хөндлөн гарах магадлал бүхий цэгүүдийг судалгаагаар тогтоож, мал, амьтан авто замыг хөндлөн гарах хоёр төвшний гарц төлөвлөх;
- Хяналтын цэгүүдийн ерөнхий

төлөвлөлтийн зураг төсөл;

- Замын дагууд замын үйлчилгээний байгууламжийн өрөнхий төлөвлөх, боломжтой газруудыг судалж, төсөллөх, холбогдох санал үндэслэлийг ИДТ-д тусгах;
- Замын дагууд үйлчилгээний байгууламж, холбогдох норм дүрмийн дагуу амрах талбай, түр зогсоол төсөллөх;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын ашиглалт, засварын хэлтсээс санал авч шаардлагатай тохиолдолд төлбөр хураах цэгийн барилгын зураг төслийг хийх;
- Газар хедлөлтөөс үзүүлэх нэлвөллийг тооцох;
- Замын трасст орсон өндөр хүчдэл, агаарын шугам, цахилгаан, дулаан, холбооны шугам сүлжээ, шилэн кабелийг зөөх, шилжүүлэх, хамгаалах ажлын нарийвчилсан зураг төсөл, нүүлгэн шилжүүлэх ажлын төсөв гаргаж баталгаажуулах;
- Авто замын трасст орсон нүүлгэн шилжүүлэх барилга байгууламжийн зураг төсөл, зардлын тооцоог гаргаж, ИДТ-д тусгах;
- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах;
- Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглолтын зураг төслийг нарийвчлан боловсруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг аудит хийлгэх;
- Төсөллөлтийг гүйцэтгэхдээ шаардлагатай тохиолдолд Захиалагчтай зөвлөлдөж, Инженерийн нарийвчилсан зураг боловсруулахтай холбогдолтой бүх асуудлыг энэхүү даалгаврын Хавсралт № 1-д тусгасан жишиг бүтцийн дагуу Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ)-д бүрэн тусгана. Тухайн газар орны газрын гадаргуугийн зураг, үндсэн реперийн сүлжээ, элемент тус бүрийн төсөллөлтөд ашигласан шалгуур үзүүлэлтүүд, анхны төсөөлөл, загвар, хэрэглэсэн арга, тооцоолтын хураангуй, материалын туршилтын үр дүн зэрийг хамруулан, цуглувансан бүх өгөгдлийг ИДТ-д хавсралт болгон тусгана.
- Зөвлөх нь бүх өгөгдөл, инженерийн нарийвчилсан зураг, баримт бичгийн үнэн зөв, иж бурдлийг бүрэн хариуцах бөгөөд шаардлагатай бол барилгын ажлын тендер шалгаруулалтын үед зохих

тодруулгыг өгнө.


- Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх;
- Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа Магадлалд хамруулах;

Хянасан:


Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын Ахлах шинжээч



Б.БОЛОР-ЭРДЭНЭ



Ч.СУГАРМАА



Д.ЗАГДРАДНАА

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын Шинжээч



Б.ЦЭРЭНСОДНОМ

БАТЛАВ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ХАТГАЛ-ХАНХ ЧИГЛЭЛИЙН 180 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТЕХНИК ЭДИЙН
ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 05 сарын 05ны өдөр

№ Т93Y-05/24

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хөвсгөл аймгийн Хатгал, Ханх сум чиглэлд аялал жуулчлалын авто зам барихаар төлөвлөн авто замын чиглэлийг тогтоох, нийгэм эдийн засгийн судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын дүгнэлт зэргийг судлах үүднээс энэхүү авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах шаардлага гарч байна.

Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлээр Хөвсгөл аймгийн Хатгал, Ханх сум чиглэлийн аялал жуулчлалын авто замын чиг сонголт, авто зам, замын байгууламжийн ерөнхий төлөвлөлт, хийц, инженерийн байгууламж, уулзвар огтполцлуудын шийдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үнэлгээ, эдийн засгийн тооцоо, нийгмийн судалгаа зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх юм.

ХОЁР. ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Уг төслөөр Хөвсгөл аймгийн Хатгал, Ханх сум чиглэлийн авто замын техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж гүйцэтгэнэ.

Төслийн нутаг дэвсгэрт Хөвсгөл аймгийн Хатгал, Чандмань-Өндөр, Рэнчинлхүмбэ, Ханх сумдын нутаг дэвсгэрийн хэсгүүд хамрагдана.

Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаанд инженерийн хайгуул судалгаа, буурь хөрсний инженер-геологийн судалгаа, замын үндсэн материалын судалгаа, трассын дагууд хамрагдаж байгаа түүх, соёлын дурсгалын судалгаа, инженер геодезийн судалгаа, авто замын трассын хувилбарууд болон сонголт, урьдчилсан төлөвлөлт, ажлын тоо хэмжээ, барилга угсралт, засвар арчлалтын ажилд шаардагдах хөрөнгийн тооцоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, хөрөнгө оруулалтын үр ашиг, мэдрэмжийн шинжилгээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга зам зэрэг багтана. (Авто зам төсөллөх ЗЗБНБД22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтыг ашиглах)

ГУРАВ: ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дүгнэлт гаргах, авто замаас болон тээвэрлэлтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр онцгой анхаарч

төлөвлөлтийг хийж ("Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтыг ашиглах)

ДӨРӨВ. СТАНДАРТ, НОРМ

"Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016

"Авто замын уур амьсгал, геотехникийн нэхцэл" АЗУАГН 2-01-01-2004

"Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32.02.11

"Хот тосгоны төлөвлөлт ба барилгажилт" БНБДЗО-01-04

"Газар хөдлөлтийн бус нутагт барилга төлевлөх" БНБД 22.01.01*/2006

"Барилга байгууламжийн инженер судалгааны нийтлэг үндэслэл БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88

"Зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэспэлийн судалгаа, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, хулээн авах журам"

"Бусад шаардлагатай Монгол Улсын холбогдох ЗЗБНБД, БНБД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэх

ТАВ. ТЭЗҮ-ИЙН ТАЙЛАНГИЙН ИЖ БҮРДЭЛ

Техник эдийн засгийн үндэслэлд дараах зүйлс багтсан байна. Доор дурдсанаас бусад тооцоо судалгааг төслийн онцлогоос хамааруулан хийх шаардлагатай бөгөөд ТЭЗҮ-гийн тайлан нь дараах заалтуудаар хязгаарлагдахгүй ("Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтыг ашиглах)

1. Инженерийн судалгааны тайлан

1.1 Авто замын хайгуул судалгаа

- Замын чигийн сонголт
- Хувилбаруудын харьцуулалт
- Байр зүйн судалгаа
- Зам-цаг уур болон уур амьсгалын хучин зүйлсийн нэхцэл нөлөөлөл, онцлог, даган гарах арга зам
- Инженер геологийн судалгаа, хучин зүйлсийн нэхцэл нөлөөлөл, онцлог, даван гарах арга зам
- Гидрологийн судалгаа

1.2 Урьдчилсан төсөллөлт

- Төсөллөлтийн стандарт ба шалгнуурууд
- Хучилтын бүтээц. хиймэл байгууламжуудын төсөллөлтийн хувилбарууд, харьцуулалт сонголт
- Гүүр хоолой бусад хиймэл байгууламжуудын төсөллөлт
- Томоохон уулзвар, орц, гарцуудын төсөллөлт
- Орон нутгийн ард иргэдийг саадгүй зорчуулах боломжоор хангасан төсөллөлт
- Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төсөллөлт;
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан

- Хувилбаруудыг урьдчилсан төсөв, харьцуулалт
- Авто зам, замын байгууламжийн цаашдын ашиглалт, засвар, арчлалт, хамгаалалтын төлөвлөлт

1.3 Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж

- Төсөл хэрэгжүүлэх аргачлал
- Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө
- Зөвлөмж

2. Эдийн засгийн шинжилгээний тайлан

2.1 Монгол Улсын болон бус нутгийн нийгэм эдийн засгийн байдал

- Хүн ам, нутаг дэвсгэрийн хөгжилд төслийн замаас үзүүлэх нөлөө
- Эдийн засгийн хөгжилд төслийн замаас үзүүлэх нөлөө
- Аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, дэд бүтэц, аялал жуулчлал, нийгмийн бусад салбаруудад төслийн замаас үзүүлэх нөлөө
- Нийгмийн хөгжил, улс, орон нутаг, бус нутгийн төсөв, унэ тарифт уг төслийн үзүүлэх нөлөө
- Нийгмийн бусад салбаруудад төслийн замаас үзүүлэх нөлөө

2.2 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлага

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн хэтийн судалгаа
- Хөдөлгөөний эрчмийн шинжилгээ
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн өөрчлөлт
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн хэтийн өсөлтийн талаарх төсөөлөл
- Аялал үүсэх, шингэх цэгийн судалгаа
- Тэнхлэгийн ачааллын судалгаа
- Стандарт тэнхлэгийн ачааллын тооцоо

2.3 Төсөллөж буй авто замын хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

- Тээвэр ашиглалтын зардал, төсөл хэрэгжсэн үеийн тээвэр ашиглалтын зардлын хэмнэлт
- Зам хэрэглэгчийн зардал, төсөл хэрэгжсэн үеийн зам хэрэглэгчийн зардлын хэмнэлт
- Тээврийн хэрэгслийн осол аваарын судалгаа, төсөл хэрэгжсэн үеийн осол аваар бууралтаас гарах хэмнэлт
- Төслийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өнөөгийн цэвэр үнэ
- Мэдрэмжийн шинжилгээ
- Эдийн засгийн ач холбогдол

2.4 Төлөвлөж буй авто замын хөрөнгө оруулалтын нийгэм эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

- Нийгэм эдийн засгийн судалгаа
- Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа
- Ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл
- Мэдрэмжийн шинжилгээ
- Нийгэм эдийн засгийн ач холбогдол

2.5 Төслийн хураангуй тайлан.

3. Байгаль орчны үнэлгээ

- 3.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
- 3.2 Түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа хамгаалах арга зам
- 3.3 Төслийн авто замаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, урьдчилсан үнэлгээ, зардал
- 3.4 Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө ("Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016 нормын хавсралт 2-ыг ашиглах)

ЗУРГАА. ОНЦГОЙ НӨХЦӨЛ

1. Хучилтын хийц болон өргөнийг төлөвлөхдөө тухайн чиглэлийн замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачаалал, хөдөлгөөний эрчим, хэтийн өсөлтийг үндэслэл болгон тэнхлэгийн ачаалал, овор хэмжээ зэргийг нарийвчлан тооцох;
2. Төлөвлөж буй авто замын трассыг тогтооходоо тухайн бус нутагт баригдсан, одоо баригдаж байгаа авто зам болон цаашид тухайн бус нутагт баригдахаар төлөвлөж байгаа авто зам, тэмр замтай огтлолцох цэгүүдийг оновчтой тогтоох, холбогдох байгууллагуудаас зөвшөөрөл авах.
3. Хот суурин газраар дайран өнгөрөх хэсгүүдийн аюулгүй нөхцөлийг хангах, хөгжлийн бодлого өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулах.
4. Трассын чиглэлийг сонгоходоо тухайн бус нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын бүтээгдэхүүн тээвэрлэхээр төлөвлөж буй төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх;
5. Төлөвлөж буй авто замын талаар орон нутгийн засаг захиргаа, ард иргэд болон орон нутгийг хариуцсан байгууллагаас санал, судалгаа авсан байх;
6. Төлөвлөж буй авто замын чиглэлийг орон нутгийн засаг захиргаа, ард иргэд дэмжсэн шийдвэрийг гаргуулсан байх;
7. Хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт гаргах, орон нутгийн засаг захиргаа, тээврийн цагдаагийн албанаас санал авч тайланд тусгах;
8. Малын бэлчээр, зэрлэг ан амьтдын шилжих хөдөлгөөнийг хязгаарлахгүй, амьдралын хэвшлийг вэрчлэхгүй, бэлчээр сэлгэх нүүдлийг саадгүй нэвтрүүлэх боломжоор хангасан шийдэл боловсруулах;
9. Авто зам, замын байгууламжийг элс болон цаснаас хамгаалах, байгаль орчинд үзүүлэх серөг нөлөөллийг баагахас асуудлыг ТЭЗҮ-ийн судалгаанд тусгах;
10. Авто замын дагуу зогсоол, амрах талбайг цогцолборын хамт ТЭЗҮ-ийн судалгаанд тусгах;
11. Баригдсан замын ашиглалт, засвар арчлалтын талаар ТЭЗҮ-д тусгах;
12. Унаган байгалийг хамгаалах, үзэсгэлэнт байгалийг хамгаалсан тусгайлсан арга хэмжээг тусгах;


ДОЛОО. ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ

Төлөвлөж байгаа авто замын Техник эдийн засгийн үндэслэлийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газарт ирүүлж хянуулсны дараа “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын дэргэдэх Авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурал болон Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж холбогдох дүгнэлтийг гаргуулан ЗТХЯ-д ирүүлнэ.

Тайланг эх хувь 1ш, хуулбар 1ш /хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/, тоон хэлбэрээр /*.dwg, pdf, KMZ/ хүлээлгэж өгнө. Тоон байдлаар бүх бичиглэлийн материалыг *.doc, *.xls өргөтгөлтэйгөөр, зураглалын материалыг *.dwg, *.shp өргөтгөлтэйгөөр баримт бичгийн бүрдлийг *.pdf өргөтгөлтэйгөөр CD болон DVD-ээр хүлээлгэн өгнө. (Монгол, Англи хэл дээр)

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга




Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Ч.СУГАРМАА

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын Ахлах шинжээч



Д.ЗАГДРАДНАА

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын шинжээч



Б.ЦЭРЭНСОДНОМ